

# Солонгос хэл суралцагчдад дуудлага заах арга

Жонь на ён  
Ёньсэ их сургууль, хэл судлал боловсролын институт  
Солонгос хэлний сургалтын төвийн профессор

## 1. Харилцан ярих чадвар ба дуудлага

Гадаад хүн мөн гадаадад амьдардаг солонгос хүнд хоёр дахь хэл буюу гадаад хэлээр солонгос хэл зааж буйг солонгос хэлний сургалт гэнэ.<sup>1</sup> Солонгос хүн, өөрөөр хэлбэл солонгос хэлийг эх хэлээр хэрэглэж буй хүмүүст зориулсан эх хэлний сургалттай харьцуулж болох юм. Тиймээс солонгос хэлний сургалт нь сургалтын зорилго буюу агуулга, сургалтын аргаас эх хэлний сургалт нь ялгаатай. Жишээлбэл: Солонгос хүнд сайн ярьж байна гэж хэлэх үе болон гадаад хүнд солонгос хэлээр сайн ярьж байна гэж хэлэх үеийн утга нь өөр юм.

Солонгос хэлний сургалтын зорилго нь бүх хэлний сургалтын зорилготой адил солонгос хэлээр харилцаж чадахуйц байх юм. Харилцан яриа нь яриа, сонсгол, бичлэг, уншлагын ур чадвараар бүрдэх бөгөөд харилцан ярианы ихэнх нь авианы хэлээр<sup>2</sup> илэрдэг яриа ба сонсголын ур чадвараар бүрддэг. Ерөнхий зорилгоор<sup>3</sup> солонгос хэл сурч буй суралцагчид ч харилцан ярианд яриа ба сонсголын ур чадвар нь өндөр бөгөөд ялангуяа доод шатны суралцагч нь солонгос хэлээр бий болж байгаа ихэнх харилцан яриа нь яриа ба сонсголоор бий болдог. Тиймээс солонгос хэл суралцагчид нь солонгос хэлээр ярьж сонсох гэсэн хүсэл өндөр. Солонгос хэлээр сонсоод ойлгож чадах ба солонгос хэлээр чөлөөтэй ярьж чаддаг суралцагч нь өөрийн солонгос хэлний чадварт итгэх итгэл болон зорилгодоо хүрснийг мэдэрдэг.

Солонгос хэл суралцагчид нь сонсголтой харьцуулахад яриа нь хүнд. Яриа бол суралцагч бий болгох ёстой ур чадвар бол сонсгол нь ойлгох ёстой учраас сонсголтой харьцуулахад харьцангуй яриа нь хэцүүг мэдэрдэг. Солонгос хэл суралцагчийн ярианы чадвар нь үгийн сангийн чадвар ба хэл зүйн чадвараа дагаад үнэлэгддэг. Гэвч дуудлагыг хэр зөв дуудаж байна гэдгээс шалтгаалан суралцагчийн солонгос хэлний ярианы чадварын талаарх үнэлгээ нь их ялгаатай. Хичнээн олон үг ашиглаж хэл зүйг тохиромжтой хэрэглэсэн байлаа ч дуудлага нь сайн биш буюу сонсож байгаа хүн ойлгоход хэцүү дуудлага бол эцэст нь солонгос хэлний чадвар сайн гэж хэлж болохгүй. “신촌” – руу явъя гэсэн боловч “시청”- руу явсан таксины жолоочийн яриа буюу “집안일이 많다” нь солонгос хэл суралцагчийн үгийг “지바이리”-аар сонсоод огт ойлгож чадаагүй солонгос хүний яриа нь солонгос хэлний дуудлага зөв байж чадахгүй байгаа харилцааны амжилтгүй жишээ юм. Солонгос хэл суралцагчид нь өөрийн дуудлагыг солонгос хүмүүс сайн ойлгож, сонсож чадахгүй бөгөөд олон удаа давтан ярих хэрэгтэй үед хүнд сэтгэл гутралыг мэдэрдэг ба солонгос хэлээр харилцахад өөртөө итгэх итгэлээ алддаг.

Солонгос хэлний дуудлага нь зөв байж чадахгүй суралцагч яриа төдийгүй харилцан ярианы чадварын бүх асуудлыг харуулж байна. Солонгос хэлээр зөв дуудаж чадахгүй байгаа суралцагч нь ихэнхдээ бичлэгт ч алдаа гаргадаг. Үгийг хэрэглэхдээ “공부”-г “곤부”-аар буруу бичих, “동생”- үгийг “도새”- тэй адил дэвсгэр үсэггүй мэт дуудангаа “도새가 있어요”-тай адил нэрийн нөхцлийг буруу хэрэглэх тохиолдолд “할까요”-г “하까요”-тай адил өөрийн дуудлагаар

<sup>1</sup> Хоёр дахь хэл болох солонгос хэл нь солонгост амьдарч байгаа гадаад хүн солонгос хэл сурч буй тохиолдол бөгөөд гадаад хэл болох солонгос хэл нь гадаадад солонгос хэл сурч буй тохиолдол юм.

<sup>2</sup> Харилцан ярианы ур чадварт яриа, сонсгол, бичлэг, уншлага байдаг бөгөөд үүнээс бичлэг ба уншлага нь бичгийн хэлээр, яриа ба сонсгол нь ярианы хэлээр бүрддэг.

<sup>3</sup> Солонгос хэл сурч буй суралцагч нь ерөнхий зорилгоор солонгос хэл суралцагч ба тусгай зорилгоор солонгос хэл суралцагчаар хуваана. Тусгай зорилгын суралцагч нь солонгост суралцах гэсэн зорилгоор суралцагч ба солонгостой холбоотой компанид ажиллах гэсэн зорилготой суралцагч зэргээр хуваана.

нөхцлөөр хувирч байгаа тохиолдол зэрэг нь дуудлагыг зөв дуудаж чадахгүй учраас гаргаж байгаа зөв бичих дүрмийн алдааны жишээ юм.

Мөн ярих үедээ зөв дуудаж чадахгүй байгаа суралцагч бусад хүний үгийг зөв сонсож ойлгох чадвар ч бас муудах учраас сонссон ярианы агуулгыг ойлгоход ч асуудал үүсдэг. Тэр төдийгүй дуудлага сайн биш суралцагч уншлагад ч бас бэрхшээл гардаг. Уншихад дуудлагад алдаа байвал уншиж буй агуулгыг тэр чигээр нь дамжуулж чадахгүй нь мэдээж бөгөөд гүйлгэж уншихад ч өөрийн дуудлагаас уншиж буй хэрэглэгдэхүүний зөв бичих дүрэм нь өөр учраас суралцагч өөрөө агуулгыг ойлгоход хэцүү.

Энэ мэт дуудлагын асуудал нь яриа төдийгүй харилцан ярианы бүх чадвартай холбоотой бөгөөд суралцагчийн солонгос хэлний чадварыг үнэлж буй үндсэн хэмжүүр болдог.

## 2.Бодит сургалтад дуудлага заах

Солонгос хэлний сургалтад суралцагчдын дуудлагын алдааг ойлгож, үүнийг яаж заах гэдэг асуудал нь солонгос хэлний багш нарт хүнд асуудал байх нь гарцаагүй. Солонгос хэл суралцагчдад дуудлагын хичээлийн зорилгыг хэрхэн тодорхойлох, дуудлагын сургалтад юуг заах, солонгос хэлний шат тус бүрийн дуудлагын сургалтын арга юу зэрэг олон асуудлыг хэлэлцэж байна. Гэвч сургалтын хөтөлбөр буюу сурах бичигт дуудлагын хичээлийн агуулга бүрэн тусгагдаагүй байгаа учраас үр дүнтэй сургалт явуулж чадахгүй байгаа нь бодит байдал юм.

Солонгос хэлний сургалтад ашигладаг сурах бичигт дуудлагыг тодорхой зааж байгаа тохиолдол ховор. Ихэнхдээ суралцагчид солонгос үсгийг сурч буй шатанд эгшиг, гийгүүлэгчийн үсэг ба авиаг хамт зааж байна. Өнөөгийн их сургуулийн харьяа солонгос хэлний сургалтын байгууллагаас голлон хэвлэгдсэн нэгдсэн сурах бичгийн ихэнх нь харилцан ярианы байдал ба сэдэв, үүргийн дагуу агуулга нь бүрдэж байна.<sup>4</sup> Иймэрхүү сурах бичгийг ашиглаж байгаа хичээл нь харилцан ярианы дасгал, үгийн сангийн дасгал, хэл зүйн дасгал, үүрэг тус бүрийн үйл ажиллагаанд голлон явуулах учраас дуудлагын хичээлийн төлөө тусдаа цаг төлөвлөх нь хэцүү юм. Чадвар тус бүрийн сурах бичиг тусдаа хэвлэгдэж байгаа байгууллага нь унших чадварын сурах бичигт дуудлагын хичээлийн хэсгийг оруулах нь бий. Гэвч иймэрхүү бүтэц нь анхан шатны сурах бичигт оруулах бөгөөд дунд шатнаас дээш сурах бичигт дуудлагын хэсгийг оруулаагүй байна.

[Хүснэгт 1] Солонгос хэлний сурах бичгийн дуудлагын дасгалын бодит жишээ(анхан шат 1)

[Уншицгаая(CD1:49)]	
·만형[마형]	저는만형이어서동생들을잘돕습니다.
·깨끗하고[깨끄타고]	이식당은깨끗하고음식도맛있습니다.
·꽃하고[꼬타고]	공원에는꽃하고나무가많습니다.
·좋다[조타]	나는한국음식이좋다.
·싫다[실타]	나는매운음식이싫다.

Эх сурвалж: 연세대학교한국어학당편(2007), 《연세한국어읽기 1》, 연세대학교출판부, 75 쪽.

[Хүснэгт 2] Солонгос хэлний сурах бичгийн дуудлагын дасгалын бодит жишээ(анхан шат 2)

[Уншицгаая (CD:28)]	
저센소리 4 /ㅎ/ + /ㅈ/ => /ㅊ/	
·많지[만치], 많지만[안치만]	차린것은많지않지만많이드세요.
·좋지[조치]	기분이좋지않은리예를보면미안해집니다.
·놓지[노치]	여기에뜨거운것을놓지마세요.
·하얗지요[하야치요]	미선씨는피부가참하얗지요?
·싫지요[실타치요]	여러분은시험이싫지요?

Эх сурвалж: 연세대학교한국어학당편(2010), 《연세한국어읽기 2》, 연세대학교출판부, 71 쪽.

<sup>4</sup> Жишээлбэл: “Ёнсэ хангүго 1” (2007)-ийн тохиолдолд сэдэв нь “Цаг агаар ба улирал” гэвэл “Улирлын талаар яриа, өнөөдрийн цаг агаар яриа, цаг агаар харьцуулж ярих, улирал үйл ажиллагаа танилцуулах”-тай адил үүргийн дагуу бүрдэж байна.

Солонгос хэл суралцагчдын дуудлага асуудалтай байна гэдгийг багш мэдлээ ч янз бүрийн бэрхшээл байдаг. Суралцагчийн дуудлага нь солонгос хүний дуудлагаас өөр бөгөөд үүний улмаас харилцаанд асуудал байгаа боловч үүнийг яаж тайлбарлаж заах вэ гэдэг нь бас нэг асуудал юм. Багш нар мэдрэмжээрээ суралцагчийн дуудлагын алдааг олж болох боловч үүнийг үр дүнтэйгээр тайлбарлаж болох хэл шинжлэлийн мэдлэг дутмаг тохиолдол их.

Буруу дуудлагыг хэлж, зөвхөн багшийн дуудлагыг дагаж дуудахаар суралцагчийн дуудлагын алдааг засна гэдэг хэцүү. Багш энгийн давтах дасгал төдийгүй тодорхой алдааны учир шалтгааныг тайлбарлаж алдааны хэлбэрээс шалтгаалан үр дүнтэй дасгалын аргыг хэрэглэх хэрэгтэй.

### 3. Суралцагчийн дуудлагын алдаа ба дуудлага заах агуулга

#### 3.1. Эгшиг

Солонгос хэлний эгшиг нь бүтэх байр, уруулын хэлбэр, хэлний өндөр намаас шалтгаалан хуваагддаг.<sup>5</sup> Дан эгшиг ‘ㅏ, ㅑ, ㅓ, ㅕ, ㅗ, ㅛ, ㅜ, ㅠ, ㅡ, ㅣ, ㅝ, ㅟ, ㅠ, ㅡ, ㅢ’ -ийн ангиллыг үзүүлбэл [Хүснэгт 1] –тэй адил. (허웅 1985:220).

[Хүснэгт 1] Солонгос хэлний дан эгшгийн ангилал

Бүтэх байр Уруулын хэлбэр Хэлний өндөр нам	Хэлний урдур		Хэлний хойгуур	
	Уруулын бус	Уруулын	Уруулын бус	Уруулын
Өндөр	ㅏ	ㅑ	ㅓ	ㅕ
Дунд	ㅛ	ㅜ	ㅠ	ㅡ
Нам	ㅣ		ㅝ	

Суралцагч солонгос хэлний эгшиг ямар байдалд хуваагдаж буйг мэдэж байж зөв дуудаж чадна. Жишээлбэл: ‘ㅏ’ нь уруулын бусаар, хэлний байрлал нам, хэлний хойгуур дуудах хэрэгтэй. ‘ㅑ’ нь уруулын, хэлний байрлал өндөр, хэлний урдур дуудах хэрэгтэй.

Суралцагч эгшгийн хуваах зарчмаар зөв дуудаж чадахгүй бол буруу дуудах нь мэдээж. Суралцагчдын эгшгийн дуудлагын алдааг ажиглаж үзвэл хуваах зарчмыг зөв дагаж чадахгүй болохоор бусад эгшигтэй ойролцоо дуудах тохиолдол олон. ‘ㅏ’ –г дуудах ёстой байхад амаа том ангайхгүй болохоор дундуур дуудагдах ‘ㅑ’-той ойролцоо дуудагдах юмуу ‘ㅓ’-г дуудахад уруулын дуудлагаар дуудвал уруулын ‘ㅓ’-тай ойролцоо буруу дуудагдана. Хэлний хойгуур дуудах ёстой ‘ㅡ’-г урдур дуудвал ‘ㅣ’ шиг сонсогдоно.

Иймэрхүү алдаа нь эгшгийн 3 төрлийн хуваах зарчимд 2 нь адилхан бөгөөд 1 нь ялгаатай байх тохиолдолд алдаа их гардаг. Хоёр эгшгийн хувьд их өөр болохоор хоорондоо тод ялгаа харагдаж байгаа эгшгийг бодвол хоёр эгшиг нь төстэй нөхцөл байх үед суралцагч андуурч буруу дуудах нь амархан. Жишээлбэл: ‘ㅑ’ ба ‘ㅓ’ нь бүгд хэлний өндөр намаар бол дундуур дуудагдах бөгөөд хэлний хойгуур дуудагдах ёстой ижил тал бий. Гэвч уруулын хэлбэрт ялгаа бий. Энэ мэт нэг янзын нөхцөлд ялгаа харуулж байгаа эгшгийг дуудахад багш болон суралцагч хоёулаа 2 авианы ялгааг тодорхой дуудах хэрэгтэй.

Уруулын хэлбэрийг зөв гаргахгүй болохоор үүсэх алдаа нь ‘거울[고울], 걱정[곡중], 공부[경부], 일본[일번], 그림[구림], 흐름[후리], 국제[극제], 축구[축그], 귀고리[기거리], 최선[체선]’ –тай адил жишээ байна. ‘ㅑ’ ба ‘ㅓ’ нь бүгд дундуур авиа бөгөөд хэлний хойгуур дуудагдах боловч ‘ㅑ’ нь уруулын бус авиа бөгөөд ‘ㅓ’ нь уруулын авиа юм. ‘ㅡ’ ба ‘ㅕ’ нь хоёулаа өндөр авиа ба хэлний хойгуур дуудагдах боловч ‘ㅡ’ нь уруулын бус авиа бөгөөд ‘ㅕ’

<sup>5</sup> Уруулын хэлбэр нь уруулын буюу уруулын бус гэж хоёр хуваадаг. Хэлний өндөр нам нь эгшгийг дуудах үед хэлний байрлал нь тангай руу өндөр байна уу нам байна уу гэдгээс шалтгаалан өндөр авиа, дунд авиа, нам авиагаар хуваадаг. Бүтэх байрлал нь эгшгийг дуудахад авиа нь хэлний урдур буюу хойгуур дуудагдаж байна уу гэдгээс шалтгаалаад хэлний урдур ба хойгуурх эгшиг гэж хуваадаг.

нь уруулын авиа юм. ‘ㄱ’ ба ‘ㄷ’, ‘ㄱ’ ба ‘ㄴ’ –г тодорхой ялгаж дуудаж чадахгүй байгаа алдаа ч бас уруулын хэлбэрийг зөв гаргаж дуудахгүй байгаа учраас үүсдэг.

Хэлний өндөр намыг зөв баримтлахгүй болохоор үүсэж буй алдаа нь ‘나무[너무], 더럽다[드럽다],

[Хүснэгт 2] Солонгос хэлний дан эгшгийн дасгал

Хуваах зарчим \ Дасгал	Эгшгийн дасгал		Үгийн дасгал	
Уруулын хэлбэр	어/오 으/우 이/위 예/외	오/어 우/으 위/이 외/예	거기/고기 그립/구름 시다/취다 세다/쇠다	저금/조금 쓰다/쑤다 기린/귀리 체면/최면
Хэлний өндөр нам	아/어/으 아/애/에/이 오/우 외/위	으/어/아 이/에/애/아 우/오 위/외	나무/너무 매주/메주 오리/우리 쇠다/취다	마리/머리 새우다/세우다 호주/후추 외박/위반
Бүтэх байр	이/으	으/이	기름/그림	호리다/호르다

그러면 [그르믄] –тай адил жишээ байна. ‘ㄷ’ ба ‘ㄱ’ нь уруулын бус авиа бөгөөд хэлний хойгуур дуудагддаг боловч ‘ㄷ’ нь хэлний байрлал нам бөгөөд ‘ㄱ’ нь хэлний байрлал дундуур авиа юм. ‘ㄱ’ ба ‘ㅡ’ нь хоёулаа уруулын бус авиа ба хэлний хойгуур дуудагддаг боловч ‘ㄱ’ нь хэлний байрлал нь дундуур авиа бөгөөд ‘ㅡ’ нь хэлний байрлал нь өндөр авиа юм. ‘ㄱ’ ба ‘ㅁ’, ‘ㄴ’ ба ‘ㄷ’ –г тодорхой ялгаж дуудаж чадахгүй байгаа алдаа ч хэлний өндөр намыг зөв гаргаж чадахгүй болохоор үүсдэг.

Бүтэх байрыг зөв гаргахгүй болохоор үүсэх алдаа нь ‘음식[임식], 은행[인행]’ –тай адил жишээ байна. ‘ㅡ’ ба ‘ㅣ’ нь хоёулаа уруулын бус авиа ба хэлний байрлал нь өндөр авиа боловч ‘ㅡ’ нь хэлний хойгуур дуудагддаг бөгөөд ‘ㅣ’ нь хэлний урдуур дуудагддаг. Хэлний хойгуур дуудах ёстой ‘ㅡ’ –г хэлний урдуур дуудвал ‘ㅣ’ –ээс ялгаж болохгүй буруу дуудагдана.

Солонгос хэлний суралцагчдад солонгос хэлний эгшгийн дуудлагыг үр дүнтэй заахын тулд суралцагчид эгшиг тус бүрийн ялгааг тодорхой ойлгож чадахуйц эгшгийн хуваах зарчмаас шалтгаалан тухайн ялгааг тодорхой заах хэрэгтэй. Юуны өмнө уруулын хэлбэрээс шалтгаалан уруулын бус ба уруулын авиаг харьцуулах дасгал хийж, хэлний өндөр намаас шалтгаалан өндөр, дунд, нам авиаг харьцуулсан дасгал хийх хэрэгтэй. Мөн бүтэх байраас шалтгаалан хэлний урдуур ба хойгуур авиаг харьцуулсан дасгал хийх хэрэгтэй.

Үүнтэй адил солонгос хэлний эгшиг нь уруулын хэлбэр, хэлний өндөр нам, бүтэх байр зэрэг хуваах зарчмыг зөв баримталж дуудвал харилцаанд асуудал үүсэхгүй.

### 3.2. Гийгүүлэгч

Солонгос хэлний гийгүүлэгч нь авианы байр, авиа гарах арга, авианы хүч зэргээс шалтгаалан дуудлага нь өөрчлөгддөг.<sup>6</sup> Энэ хуваах зарчмыг харуулбал: [Хүснэгт 3] –тай адил. (허웅 1985:223~224).

Солонгос хэлний гийгүүлэгч нь хуваах зарчмаар 19 хуваадаг ба энэ зарчмаар дуудахад харилцаанд асуудал гарахгүй. Жишээлбэл: ‘ㅁ’ нь хоёр уруулыг нийлүүлж дуудах ёстой ба ‘ㅂ’ нь хэлний үзүүр түүш хэсгээр дуудах хэрэгтэй. ‘ㄷ’ нь хэлний угийг тагнайд нааж дуудах ёстой ба ‘ㄴ’ нь хэлний үзүүрийг түүшинд нааж, хамраар дуудах хэрэгтэй. Багш солонгос хэлний суралцагчдад гийгүүлэгч тус бүрийн онцлогийг сайн ойлгож зарчмын дагуу дуудахуйц заах хэрэгтэй.

<sup>6</sup> Авианы байр нь гийгүүлэгчийг дуудаж байгаа байрлалаас шалтгаалан уруулын, хэлний үзүүр ба түүш, тагнайн, хоолойн гэж хуваадаг. Авиа гарах арга нь гийгүүлэгчийг дуудахад уушгинаас хий гарч байгаа аргаас шалтгаалан хамжих, хамжин шүргэх, шүргэх, хамрын, урсах гэж хуваадаг. Авианы хүч нь гийгүүлэгчийг дуудахад гарч байгаа уушгины хийн хүчээс шалтгаалан энгийн, хатуу, чанга гэж хуваадаг.

[Хүснэгт 3] Солонгос хэлний гийгүүлэгч ба хуваах зарчим

Арга		Байр	Уруулын	Хэлний ҮЗҮҮР, ТҮҮШ	Тагнайн	Хоолойн
Хамжих	Энгийн хатуу чанга		ㅂ	ㅃ	ㅅ	
			ㅈ	ㅉ	ㅆ	
			ㅊ	ㅏ	ㅑ	
Хамжин шүргэх	Энгийн хатуу чанга				ㅈ	
					ㅊ	
					ㅊ	
Шүргэх	Энгийн Хатуу			ㅅ		ㅎ
Хамрын			ㅁ	ㄴ	ㅇ	
Урсах				ㄹ		

Суралцагч нь гийгүүлэгчийн хуваах зарчмын дагуу дуудаж чадахгүй бол буруу дуудаж, үүний улмаас харилцаанд асуудал үүсдэг. Суралцагчдын гийгүүлэгчийн дуудлагын алдаа нь гийгүүлэгчийн хуваах зарчимд бусад нөхцөл нь адил бөгөөд нэг нөхцөл нь өөр тохиолдолд, өөрөөр хэлбэл ижил тал нь их байдаг гийгүүлэгч хооронд үүсдэг.

Үгийн эхэнд орсон гийгүүлэгчид буруу дуудах тохиолдолд авианы байр нь адил ба авиа гарах арга нь өөр учраас өөр авиагаар хуваагддаг ‘ㄷ’ ба ‘ㄹ’, ‘ㅅ’ ба ‘ㅈ’ байна. ‘바다’ –г [바라]-д ойролцоо хэлийг чичрүүлж дуудах алдаа нь дээрх жишээ, энэ нь ‘ㄷ’-г дуудахад хэлний үзүүрийг түүшинд нааж дуудах хэрэгтэй гэдгийг суралцагч сайн ойлгож чадаагүй учраас юм. ‘시다’-г [지다]-д ойролцоо хэлийг тагнайд нааж дуудаж буй алдаа нь ‘ㅅ’-г дуудахад хэл болон тагнайг шүргэж дуудахгүй бөгөөд хэлийг тагнайд нааж дууддаг учраас үүсдэг.

Авианы байр ба авиа гарах арга нь адил боловч авианы хүч нь өөр энгийн, хатуу, чанга авиаг ялгаж чадахгүй буруу дуудаж байгаа жишээ маш их. Солонгос хэл суралцагчдын дунд ‘비다’ ба ‘빼다’ ба ‘피다’ –г ялгаж дуудаж чадахгүй бөгөөд ‘대다’ ба ‘때다’, ‘따다’ ба ‘타다’ –г ялгаж дуудаж чадахгүй тохиолдол олон. Мөн ‘가다’ ба ‘까다’, ‘사다’ ба ‘싸다’, ‘지다’ ба ‘찌다’ ба ‘치다’ –г зөв дуудахад хэцүү гэж боддог. Эдгээр гийгүүлэгч нь авианы хүчээр хуваагдах боловч дуудахад гарч байгаа уушгины хүчний ялгааг суралцагч ойлгож чадаагүй учраас зөв дуудаж чадахгүй байгаа юм.

Дэвсгэр үсгээр хэрэглэгдсэн гийгүүлэгч нь үгийн эхэнд хэрэглэгдсэн гийгүүлэгчээс алдаа нь их. Авиа гарах арга ба авианы хүч нь адил боловч авианы байр нь л өөр ‘ㅂ, ㅃ, ㅅ’ ба ‘ㅁ, ㄴ, ㅇ’ нь янз бүрийн алдаа гардаг. Энэ нь гийгүүлэгч тус бүрийн авианы байрыг зөв гаргаж дуудахгүй байгаа учраас юм. Жишээлбэл: ‘입구’ –г [익구] –тэй адил дуудах нь хоёр уруулыг нааж ‘ㅂ’ –г дуудах хэрэгтэй байхад хоёр уруулыг нийлүүлэлгүй буруу дууддаг учраас юм. ‘복잡’ –г [볼잡] –тай адил дуудах тохиолдол ч байдаг бөгөөд энэ нь хэлний үзүүр түүшинд хүрэхгүй байх хэрэгтэй ба ‘ㅅ’ –г ‘ㅃ’ –тэй адил хэлний үзүүр түүшинд хүрч дууддаг учраас юм. ‘강남’ –г [간남] –тай адил дуудах тохиолдолд ‘감동’ –г [간동]-тай адил дуудах тохиолдолд ч ‘ㅇ’ ба ‘ㅁ’ –ийн авианы байрыг зөв гаргаж дуудаагүй учраас үүсч буй алдаа юм. ‘문법’ –г [뽄뽄]-р дуудах юмуу ‘음식’-г [은식]-тэй төстэй дуудах нь ч бүгд авианы байрыг баримтлаагүй учраас юм.

Дэвсгэр үсгийг дуудахад үүсдэг бас нэг алдаа нь хамжих гийгүүлэгч ‘ㅂ, ㅃ, ㅅ’-р төгсөх үед үүнийг дахин нэг үе байгаа мэт дуудна. ‘수박’ –г [수바그], ‘수첩’ –г [수처브] –той адил дуудах нь дэвсгэр үсгээр төгсөх үед үүнийг тод дууддаггүй зарчмыг мэддэггүйн улмаас үеийн эхэнд орсон гийгүүлэгч шиг дууддаг учраас юм. ‘맷다’-г [맷브다] –тэй ойролцоо дуудах нь ч тод дуудах ёсгүй дэвсгэр үсгийг тод дуудсан учраас үүсч буй алдаа юм.

Солонгос хэл суралцагчдын гийгүүлэгчийг дуудах алдааг багасгахын тулд гийгүүлэгч тус бүрийн онцлогийг тодорхой тайлбарлаж түүний дагуу дуудахуйц заах хэрэгтэй. Гийгүүлэгч дунд хоёр нөхцөл нь адил бөгөөд нэг нөхцөл нь өөр гийгүүлэгчүүдийг хамт дасгал хийвэл үр дүнтэй. Суралцагч гийгүүлэгч хоорондын ялгааг жаахан илүү тодорхой ойлгож чадах учраас юм.

[Хүснэгт 4] Солонгос хэлний гийгүүлэгчийн дасгал

Дасгал Хуваах зарчим	Үгийн эхний авианы дасгал	Дэвсгэр үсгийн дасгал	
Авианы байр	바/다/사/자/가 빠/따/짜/까/까 과/타/카 마/나/아	바다/사자 빠다/따다 팔/탈/갈 매다/내다	밥/밭/박 입다/잇다/익다 앞/밑/부엌 감/간/강 감기/간장/강릉
Авиа гарах арга	바/마 다/나/라 가/아	병/명 두부/누구	갑/감 신다/신다 국/궁 갑시다/감사 닫다/달다 약국/양궁
Авианы хүч <sup>7</sup>	바/빠/과 다/따/타 가/까/카	바다/과다 달/말/탈 개다/깨다	

### 3.3. Аялга ба авианы өөрчлөлт

Солонгос хэл суралцагчдын дуудлага сайн биш байх юмуу эвгүй зүйл нь эгшиг ба гийгүүлэгчийг зөв дуудаж чадахгүй байх нь байдаг боловч аялга нь солонгос хэлээр хэлэлцэгчээс өөр буюу авианы өөрчлөлтийн дүрмийг баримтлахгүй байх нь ч бий.

Солонгос хэлний аялга нь өгүүлбэрийн төрлөөс шалтгаалан өөрчлөгддөг. Хүүрнэх өгүүлбэр буюу аялга өгүүлбэр нь өгүүлбэрийн төгсгөлийг бууруулдаг бол асуух өгүүлбэр нь өгүүлбэрийн төгсгөлийг өргөдөг. Гэвч солонгос хэл суралцагчдын дунд өгүүлбэрийн төгсгөлийг өргөж бууруулах төдийгүй холбоо үг бүрт аялагыг өргөж дууддаг учраас эвгүй тохиолдол байна. Жишээлбэл: ‘제가 한번 해 보겠습니다.’ –г [제가 한번 해 보겠습니다] –тай адил нэг холбоо үг дуусах бүрт төгсгөлийг өргөж дуудаж буй юм. Мөн өөр жишээ нь [제가 한번 해 보겠습니다] –тай адил холбоо үг эхлэх үед аялгыг өргөж дууддаг болохоор яг холбоо үгийн өмнө өргөлт өгсөн мэт дуудах юм. Иймэрхүү алдаа нь суралцагч эх хэлний нөлөө болох тохиолдол их бөгөөд алдааг засахын тулд солонгос хэлний аялгын онцлогийг тайлбарлаж өгүүлбэрийн нэгжээр дасгалжуулах хэрэгтэй.

Солонгос хэлний дуудлагыг заахад эгшиг ба гийгүүлэгч тус бүрт дуудлагыг зөв ойлгож дуудаж чадахуйц заахаас гадна онцгой орчинд дуудлага нь өөрчлөгдөж буй зарчмыг хэлж үүнийг дагаж дуудахуйцаар заах хэрэгтэй. Бичгийн дагуу дуудахгүй ба өөр дуудлагаар сольж дуудах хэрэгтэй гэдэг нь солонгос хэл суралцагчдад хэцүү хэсэг юм. Гэвч иймэрхүү авианы өөрчлөлтийн зарчмыг баримталж дуудахад чөлөөтэй солонгос хэлний чадвартай болж болно. ‘먹었어요’ –г [머거쎄요] –р дуудалгүй [먹걸쎄요] буюу [먹걸어요] –тай адил дуудагдах юмуу ‘할일’을 [할릴] –р дуудалгүй [하릴] –р дуудна гэвэл сонсоход эвгүй төдийгүй харилцаанд ч үр дүнгүй юм. Гэвч суралцагчдад солонгос хэлний авианы өөрчлөлтийн дүрмийг бүгд цээжилхүйц заах нь хэцүү бөгөөд яриа буюу уншлагын цагт давталтаар давтах нь сайн арга юм. Солонгос хэлийг заадаг багш ямар орчинд онцгой эгшиг буюу гийгүүлэгч өөр дуудлагаар өөрчлөгдөж буй талаар авианы өөрчлөлтийн дүрмийг суралцагчид сайн тайлбарлах ёстой бөгөөд суралцагчдад хэрэгтэй үг буюу өгүүлбэрийн жишээг харуулна. <Зөв дуудах зүй>-ийн ‘5-р бүлэг авиа ижилсэх, 6-р бүлэг авиа хагуурах, 7-р бүлэг авиа нэмэгдэх’ хэсэг нь солонгос

<sup>7</sup>Авианы хүчээр хуваагддаг гийгүүлэгч “ㅂ, ㅃ, ㅍ”, “ㄷ, ㅌ, ㅌ”, “ㄱ, ㅋ, ㆁ” нь дэвсгэр үсгээр хэрэглэгдвэл “ㅂ”, “ㄷ”, “ㄱ” –р дуудлага нь адил учраас дэвсгэр үсгийн дасгал нь үр дүнтэй байж чадахгүй. Өөрөөр хэлбэл “ㅃ다” ба “ㅌ다”-ийн “ㅂ” ба “ㅌ” нь бүгд [ㅂ]-р дуудагдах бөгөөд “ㄷ다” ба “ㄷ다”-ийн “ㄷ” ба “ㅌ” нь бүгд [ㄷ] –р дуудагдана.

хэлний авианы өөрчлөлтийн дүрмийн талаар тайлбарлаж байгаа бөгөөд солонгос хэлний сургалтад үүнийг иш татаж болох юм.

#### 4. Дуудлагын сургалтын талаарх санал

Солонгос хэл суралцагчид солонгос хэлний эгшиг ба гийгүүлэгчийг буруу дуудах нь суралцагчийн эх хэлний нөлөөний улмаас байх боловч солонгос хэлний эгшиг ба гийгүүлэгчийн хуваах зарчмыг сайн ойлгож чадаагүй учраас байх тохиолдол олон. Жишээлбэл: '어머니'-г [오모니]-тай адил дуудаж буй суралцагч '오늘'-г дуудахдаа [어늘] –тэй төстэй дууддаг. Энэ нь суралцагч 'ㅏ' ба 'ㅑ' –г дуудаж чадахгүй биш хэзээ уруулын бөгөөд хэзээ уруулын бусаар дуудахыг мэдэхгүй учраас юм. Мөн '신문'-г [심문] гэж дууддаг суралцагч '강남' -г [간남] шиг дуудах тохиолдол байна. Ийм суралцагч ч хэлний үзүүрийг түүшинд нааж дууддаг 'ㄴ' ба хоёр уруулаа нааж дуудах ёстой 'ㅍ'-г дуудаж чадахгүй биш хэзээ түүнийг баримталж дуудах ёстойг мэдэхгүй учраас алдаа гаргаж байна.

Энэ мэт солонгос хэл суралцагчийн дуудлагын алдаа нь ерөнхийдөө суралцагч онцгой эгшиг ба гийгүүлэгчийг дуудаж чадахгүй учраас биш тус бүр эгшиг ба гийгүүлэгчийг дуудахын тулд ямар зарчмаар дуудах ёстойг сайн сурч чадаагүй учраас юм. Иймэрхүү асуудлыг шийдвэрлэж болох арга бол солонгос хэлний багш нь солонгос хэлний дуудлагын талаар мэргэшсэн мэдлэгт суурилан суралцагчийн алдааг таамаглаж үүнээс сэргийлж чадахуйц хийх юм. Солонгос хэлний эгшиг ба гийгүүлэгчийн тогтолцоонд ямар эгшиг болон ямар гийгүүлэгч амархан андуурч болохыг таамаглаж дуудлагыг заавал суралцагчийн дуудлагын алдааг багасгаж чадна.

Солонгос хэлний сургалтад хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрт суралцагчдын дуудлагын сургалтын агуулга ихэнх нь багтдаггүй байна. Тиймээс багш суралцагчийн дуудлагын алдааг мэдлээ ч үүнийг заах боломж дутмаг. Иймэрхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд дуудлагын сургалтын төлөөх агуулгыг сурах бичигт нийтлүүлж багш дуудлагын сургалтын материалаар ашиглах юмуу суралцагчийн дуудлагын алдааг олж түүнийг засаж болох тусгай хичээлийг бүрдүүлэх ёстой.

Дуудлага нь сургалтын эхэн үе маш чухал ба солонгос хэлний сургалтын анхан шатанд сайн заах ёстой. Тус бүрийн эгшиг ба гийгүүлэгчийн ялгааг ойлгож түүнийг дуудаж чадахуйц зааж, цаашид авианы өөрчлөлт буюу аялгад үүсч байгаа алдааг засаж чадахуйцаар хийх хэрэгтэй.

Солонгос хэлний дуудлага нь ярианаас эхлээд бүх харилцан ярианы чадварт нөлөөлдөг. Тиймээс дуудлагын чухал шинжийг ойлгож түүнийг зөв сурч чадахуйцаар багш сургалтандаа ч анхаарлаа хандуулах ёстой юм.

## Ном зүй

- 곽지영외(2007), 《한국어교수법의실제》, 연세대학교출판부.  
연세대학교한국어학당편(1995), 《한국어발음》, 연세대학교출판부.  
연세대학교한국어학당편(2007), 《연세한국어읽기 1》, 연세대학교출판부.  
연세대학교한국어학당편(2007), 《연세한국어 1》, 연세대학교출판부.  
전나영(2008), 한국어학습자의발음문제와교수방법, 《문법연구》8, 한국문법교육학회, 249~276.  
허용·김선정(2006), 《외국어로서의한국어발음교육론》, 박이정.  
허용(1985), 《국어음운학-우리말소리의오늘·어제-》, 샘문화사.  
국립국어원표준발음법 <http://www.korean.go.kr>

Сэтгүүлийн нэр: Сэгүгө сэнхуал  
Хэвлэсэн газар: БНСУ-ын Эх хэлний академи  
Сэтгүүлийн дугаар: 2015 оны 25-р боть, 1дэх дугаар(хавар)  
Хуудас: 29-44  
Орчуулсан: Ё.Нямхишиг  
2016.01.20